

2023 он

ҮНИЙН САНАЛ

Бүх үйлчилгээг цогцоор нь ашиглах
уян хатан нөхцөлтэй үнийн багцууд

АГУУЛГА

Бүтээгдэхүүн буюу шийдэл	3
Платформыг хэрхэн ашиглах вэ?	4
Үнийн санал	5
Үнийн саналын түгээмэл асуултууд	8
Бидний зорилго	9
Багийн танилцуулга	10
Холбоо барих	12

ШИЙДЭЛ

Бид танд бусдаас ялгарах худалдааны вэбсайтаа богино хугацаанд хялбар бүтээхээс гадна онлайнаар худалдаа эрхлэхэд зайлшгүй шаардлагатай цогц систем агуулсан үйлчилгээг санал болгож байна.



Вэбсайт + Сагс төлбөрийн хэрэгсэл

- Бэлэн загвар сонгон богино хугацаанд вэбсайтаа бүтээх
 - Код бичихгүйгээр, яг өөрийн брэндэд тохирох өнгө, загвараар вэбсайтаа бүтээх
 - Нэмэлт зардалгүйгээр вэбсайтаа хөгжүүлэх, хөтлөх
 - Сагс төлбөрийн систем, elastic хайлтын систем ... дэвшилтэт технологиуд агуулсан
-



Захиалгын удирдлага

- Вэбсайт, социал, утсаар ирсэн бүх захиалгаа нэг системд цэгцтэй бүртгэх
 - Олон ажилтан зэрэг ажиллаж үйл ажиллагаагаа алдаагүй, хялбар болгох
 - Захиалгаа хугацаа, статусаар шүүж харах, үр дүнтэй удирдах
 - Захиалга бүрийг цаг алдалгүй борлуулалт болгох боломж үүснэ.
-



Бараа материалын удирдлага

- Гадаад, дотоод худалдан авалтаа бүртгэх, хянах
 - Үлдэгдлээ лайваар хянах, удирдах
 - Олон агуулах үүсгэн бараа материалаа байршуулах, тус бүрээр хянах
-



Тайлан анализ

- Захиалга, борлуулалт, бараа материал, үр ашгийн тайланг нэгтгэн харах
-



Хүргэлтийн апп

- Хүргэлтийн ажилтан бүртгэх, захиалгаа хүргэлтийн ажилтанд хуваарилах систем
 - Хүргэлтийн ажилтны аппликэйшн
 - Хүргэлтийн биелэлтийг хянах, хүргэлтийн ажилтны тооцоо нийлэх функц
-

Онлайн худалдааны салбарт туршлагатай мэргэжилтнүүд дэвшилтэт технологи, салбарын нөү-хау шингээн Монголын нөхцөлд тохирсон зөв шийдлийг шингээсэн цогц системийг санал болгож байна.

ХЭРХЭН АШИГЛАХ ВЭ?

Ямар хугацаа зарцуулах вэ?

Энэ нь хийхээр төлөвлөж буй вэбсайтын загвар, цар хүрээ, контентын бэлтгэл ажил зэргээс хамаарна. Бэлтгэлээ хангасан бол 3-4 цагийн дотор вэбсайтаа тохируулан ажиллуулах ч боломжтой

Юу бэлтгэх вэ?

- Вэбсайтын загвараа төсөөлөн бэлдэх
- Ашиглах зураг, текст
- Барааны мэдээлэл

Вэбсайтаа хэрхэн хийх вэ?

Баннер, товч зэрэг хүссэн бүрдэл хэсгүүдийг сонгон чирч байршуулах (drag-and-drop) хялбар функцыг ашиглан код бичихгүйгээр вэбсайтаа өөрөө бүтээх боломжтой.

Алхам 1

Платформд бүртгүүлэх

Алхам 2

Ангилал үүсгэх,
Бараа оруулах

Алхам 3

Вэбсайтын загвар сонгох
(бэлэн загвар ашиглах эсвэл өөрийн брэндэд тохируулан шинэ дизайн үүсгэх)

Алхам 4

Загварын дагуу
мэдээллээ оруулснаар
вэбсайт бэлэн болно

Алхам 5

Төлбөрийн хүлээн данс
холбох, тохируулах

ҮНИЙН САНАЛ

Багцууд	Стандарт	Ахисан	Премиум
Сарын суурь хураамж	59,000	200,000	500,000
Ажилтны тоо	2	8	15
Агуулахын тоо	2	5	15
Борлуулалтын шимтгэл	1%	0.8%	0.6%
Хүргэлтийн апп	+	+	+

ТУРШИЛТЫН БАГЦ (1, 2)

- Эхний 7 хоног үнэгүй турших боломжтой
- 5000₮/30 хоног багцыг нэг удаа ашиглах боломжтой

НЭМЭЛТ ҮЙЛЧИЛГЭЭ

Вэбсайтаа үүсгэхтэй холбоотой мэргэжлийн үйлчилгээ авах боломжтой.

Вэб дизайн гаргах

Бэлэн загвар ашиглахгүйгээр өөрийн брэндийн ялгарал, өнгө аясыг харуулсан, дахин давтагдахгүй вэбсайт бүтээж болох ба маркетшопын мэргэжлийн дизайнераар дизайнаа гаргуулах боломжтой.

Бүтээгдэхүүний зураг авалт

Вэбсайтын дизайнд нөлөөлдөг чухал зүйлсийн нэг нь бүтээгдэхүүний зураг байдаг. Хэрэв та бүтээгдэхүүндээ зураг бэлдэж амжаагүй бол манай зураг авалтын үйлчилгээг авах боломжтой.

Барааны мэдээлэл оруулах

Вэбсайтаа ашиглалтад оруулахад хугацаа авч болох нэг ажил нь барааны мэдээлэл оруулах байдаг. Маркетшопоос барааны мэдээлэл вэбсайтад оруулах үйлчилгээг авснаар вэбсайтаа илүү хурдан хугацаанд бэлэн болгох юм.

ҮНИЙН САНАЛ АВАХ

→ [✉ info@market.shop](mailto:info@market.shop) ☎ 7777 3330

ТҮГЭЭМЭЛ АСУУЛТУУД

Ажилтны тоо гэж юу вэ?

- Дэлгүүр үүсгэсэн эзнээс гадна дэлгүүр удирдах ажилтны тоо. Ажилтныг дэлгүүрийн аль хэсгийг харах, засах, нэмэх, устгах боломжтойг нь эрхийн тохиргоогоор зааглан үүсгэх боломжтой.

Агуулахын тоо гэж юу вэ?

- Бараа байршуулан үлдэгдлийг хянаж буй байршил тус бүрийг агуулах гэж үзнэ. Агуулах хооронд барааны үлдэгдэл шилжүүлэх, агуулахаа сонгон борлуулалт хийх боломжтой.

Аль багцийг сонгох вэ?

- Дэлгүүр удирдах ажилтны тоо, агуулахын байршил, борлуулалтын хэмжээ зэргээ тооцоолон өөрийн бизнест тохирох багцыг сонгохыг зөвлөж байна.

Борлуулалтын шимтгэлийг хэрхэн тооцох вэ?

- Зөвхөн амжилттай борлуулсан захиалгаас шиймтгэл тооцно. Захиалгын “биелэлтийн төлөв”-өөр амжилттай борлуулалтыг тооцон сарын сүүлд нэхэмжлэхээр тооцоо хийнэ.

Нэмэлт зардал гарах уу?

- Нэмэлт зардал гарахгүй гэж үзэж болно. Туслах домэйн, серверийн зардал, SSL сертификат гэх мэт программ ажиллуулахад гардаг зардлууд бүгд багтсан.

Төлбөрөө сар сард нь төлж болох уу?

- Болно. Сарын суурь хураамжийг сарын эхэнд админы тохиргоо хэсгээс нэхэмжлэх үүүсгэн төлнө. Борлуулалтын шимтгэлийг сарын сүүлд нэхэмжлэхийн дагуу төлнө.

Вэбсайтын домэйн төлбөртэй юу?

- Маркетшоп платформын туслах домэйн ашиглахад төлбөргүй. Хэрэв та өөрийн нэрээр тусгай домэйн ашиглахыг хүсвэл домэйнээ үндэсний дата төвөөс аван холбох боломжтой.

- Танд нэмэлт асуулт байвал имэйл эсвэл утсаар холбогдон асууна уу.

✉ info@market.shop ☎ 7777 3330

БИДНИЙ ТУХАЙ


Манай багийн зорилго, зорилт, зарчим цахимаар худалдаа эрхлэгч, хэрэглэгч таны бизнесийн хөгжлийг дэмжихээс гадна, ирээдүйн зорилготой нийцнэ гэдэгт бид итгэж байна.

Эрхэм зорилго

Бид худалдааны бизнесийн өсөлтийг хөтлөх дэвшилтэт технологи, ухаалаг шийдлээр тэргүүлэгч байна.

Алсын хараа

- Үндэсний үйлдвэрлэгчдийн бараа, бүтээгдэхүүнээ гадаад зах зээлд нэвтрүүлэх технологийн хамтрагч нь болно
- Бүтээгдэхүүнээ олон улсын зах зээлд нэвтрүүлнэ



БАГИЙН ТАНИЛЦУУЛГА

Хөгжүүлэлт

Монгол болон гадаадын томоохон төслүүдэд ажилласан арвин туршлагатай хөгжүүлэгчдээс манай баг бүрдсэн.

Маркетшоп платформд сүүлийн үеийн технологийн шийдлүүдийг ашигласан бөгөөд цаашид дэвшилтэт технологиудыг байнга хөгжүүлнэ.

Баримталдаг зарчим

- Дэвшилтэт технологи
- Бүтээлч, шинэлэг байдал
- Тасралтгүй хөгжил
- Хамтын ажиллагаа

Борлуулалт, маркетинг

Цахим худалдааны салбарт туршлагатай мэргэжилтнүүд салбарын нөү-хау шингэсэн зөв шийдлийг хамтран боловсруулсан.

Цаашид хэрэглэгчидтэйгээ ойр байж, хэрэглэгч болон бизнесийн гүүр нь болж яг хэрэглэгчийн хэрэгцээнд нийцсэн шийдлийг гарган бүтээгдэхүүнээ хөгжүүлэхийг зорилгоо болгон ажиллаж байна.

Платформын чадамжийг бүрэн дүүрэн ойлгох, хэрэглэхэд нь туслах үлмаар бизнесээ, борлуулалтаа өсгөхөд нь дэмжлэг үзүүлэхийн тулд борлуулалт, маркетинг, дизайн, санхүүгийн багийнхан мэргэжлийн, найрсаг үйлчилгээг үзүүлэн хамтран ажиллахад бэлэн байна.

Хамт олон





Найдвартай, мэргэжлийн хамт олон

Таны бизнестийн технологийн найдвартай байдлыг
бүрэн хариуцна.



ХОЛБОО БАРИХ

Утас

976-7777 3330

Имэйл

info@market.shop

Вэбсайт

www.market.shop

Фэйсбүүк хаяг

Market.shop

Инстаграм хаяг

Marketshop_Ecommerce



Маркетшоп худалдааны технологи ХХК